



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр


Дугаар А/48

Хархорин сум

**Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3 дэх заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Бэлчээр хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А/70 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А/210 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Тус сумын Нарийн хүр, Онгоцон-Ухаа, Жалбаа, Шанх багийн 4900 га бэлчээрт микробиологийн аргаар хөнөөлт мэрэгчтэй тэмцэх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.
- 2.Мэрэгч устгал зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
- 3.Нарийн хүр багийн Өртөө гарам, Талын дөрвөлжин, Зүүн намаг, Онгоцон-Ухаа багийн Хадан хошуу, Зогсоол толгой, Худаг элстий, Ар элстий, Улаан худаг, дөрөлжин, Цагаан нуур, Жалбаа багийн Тасархай,Тариат, Тодон, Өвөр элстий, Шанх багийн Шар бүрд, Дүгэрэг, Өлзийт овоо, Сарын гол, Өрхтий, Хөшөөн дэнж, Таван цохио, Голын овоот, Дэрсэн худаг, Бумбат орчмын бэлчээрийг 2025 оны 04 дүгээр сарын 03 -ны өдрөөс эхлэн 15 хоногийн хугацаанд чөлөөлж, бэлчээрт мал оруулахгүй байхыг 4, 5, 6, 7 дугаар багийн Засаг дарга, малчдад үүрэг болгосугай.
- 4.Микробиологийн аргаар мэрэгчтэй тэмцэх ажлыг малчдаар гүйцэтгүүлж, удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Батчулуун)-д даалгасугай.
- 5.Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ц.Баатарсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

